



73

СУХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 025

Баруун-Урт

Г  
Малын бруцеллээст тэмцэх аймгийн стратеги  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 13 дахь заалт, Хүнс Хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А-154 тоот тушаалыг үндэслэн Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.3.1.2, 3.3.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Малын бруцеллээст тэмцэх стратеги, төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Малын бруцеллээст тэмцэх стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээг авч ажиллахыг төрийн сангийн ерөнхий нягтлан /Б.Одончимэг/, ХХААГ-ын дарга /Т.Ган-очир/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Тус стратегийн хүрээнд тандалт судалгаа хийх график төлөвлөгөө гарган ажиллаж, стратегийн хэрэгжилтийн үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан ИТХ-д танилцуулахыг ХХААГ-ын Мал эмнэлгийн хэлтсийн дарга /Т.Тунгалаг/-т даалгасугай.



741

Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2016 оны 04 дугаар сарын 25.. ёдрийн  
25... тогтоолын 1-р хавсралт

**СҮХБААТАР АЙМГИЙН МАЛЫН БРУЦЕЛЛЁЗТОЙ ТЭМЦЭХ  
СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэхүү стратегид Сүхбаатар аймгийн малын бруцеллёстай тэмцэх, түүнийг хяналтанд авах чиглэлээр 2021 оны эцэс хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, тавьсан зорилтыг тодорхойлов.

Тус стратегийн баримт бичиг нь Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт Малын бруцеллёстай тэмцэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулахдаа энэхүү баримт бичгээс гадна, Малын бруцеллёстай тэмцэх зааврын хамгийн сүүлд батлагдсан хувилбарыг дагаж мөрдөнө.

## НЭГ: ҮНДЭСЛЭЛ

Монгол улсад оношлогдсон зооноз өвчинүүд дотроос бруцеллёз нь нийгмийн эрүүл мэндэд хамгийн их хор хохирол учруулдаг.

ХӨСҮТ-өөс гаргасан сүүлийн 10 жилийн мэдээнээс харахад жил бүр хүний бруцеллёзын 500 орчим тохиолдол бүртгэгдэж, дээрх хугацаанд нийт 5516 хүн уг өвчний халдвартыг шинээр авсан болох нь тогтоогджээ. Хөдөө орон нутгийн хүн эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаагаас шалтгаалан бруцеллёзын тохиолдол бүрийг бүртгэх, хяналтанд авах, эмчилгээ хийх нөхцөл бололцоо хомс байна. Үүнтэй холбоотойгоор Монгол улсад хүний бруцеллёзын мэдээлэгдэхгүй байгаа тохиолдолын тоо нэн өндөр буюу 1:40 байдаг гэсэн тооцоог гаргажээ өөрөөр хэлбэл бруцеллёстай нэг өвчтнийг бүртгэж авсан ч цаана нь халдвар авсан 40 орчим хүнийг бүртгэж чадахгүй байна.

Нэг сая хүн амд ногдох хүний бруцеллёзын өвчлөлөөр дэлхийд хамгийн их буюу 500-аас дээш тохиолдол бүртгэгддэг Сири, Монгол зэрэг улсууд байдаг талаар 2006 онд мэдээлжээ. ХӨСҮТ-ийн 2000-2013 оны тайланд улсын хэмжээний нийт сумдын 91,6 % /305/-д хүний бруцеллёз бүртгэгдэж, 50-иас дээш тохиолдолтой 29 сум байгаагаас Архангай аймгийн Цэцэрлэг суманд 85, Булган суманд 95, Дорнод аймгийн Баянтуумэн суманд 93, Булган суманд 100, Увс аймгийн Давст суманд 106 хүний тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүний бруцеллёзын халдварлалтын түвшин өндөр байгаа нь малын бруцеллёзын халдварлалт, тархалттай шууд холбоотой буюу иргэд дөнгөж гарсан төл, малын эхэс, хаг зэрэг болон нянгаар бохирлогдсон эд хэрэгсэлд шууд хүрэх, боловсруулаагүй малын гаралтай бүтээгдэхүүн хэрэглэдэгтэй холбоотой.

Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын нийт 337 сум, 1026 баг, 11528 малчин өрхийн нийт 167981 малд /тэмээ 10937, үхэр 36318, хонь 59946, ямаа 60780/ 2011 онд хийсэн тандалтын түүвэр шинжилгээний дүнгээр шинжилсэн малын 0,9 %, үүнээс ямааны 0,53 %, хонины 0,72 %, тэмээний 0,74 %, үхрийн 1,8 % нь тус тус эерэг гарсан байна. Завхан, Дорнод, Дархан-Уул, Архангай аймгийн үхрийн 2,7-5,8 %, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс, Дорноговь аймгийн тэмээний 1,2-5,8 % тус тус эерэг байна. Бруцеллёзын эерэг урвалтай мал бүх аймагт илэрсэн ба нийт сумын 57,3 %, багийн 31,3 % харин өрх/хот айл/-ийн дундажаар 8,0 % нь бруцеллёзын халдварлалт, тархалттай байна.

Малын бруцеллёзыг хяналтад авч, улмаар эрүүлжүүлэхэд өртөмтий малыг массаар дархлаажуулах эсвэл шинжлээд нядлах гэсэн 2 үндсэн арга байдаг. Нүүдлийн

мал аж ахуй эрхэлдэг манай орны хувьд шинжлээд нядлах аргыг хэрэглэх боломж хомс байна. Учир нь шинжлээд нядлах аргыг хэрэгжүүлэхийн тулд дараах нөхцөл шаардлагуудыг хангасан байх, малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн хянадаг байх, шаардлага хангасан мал бүртгэлийн тогтолцоотой байх, халдварт илэрсэн малыг богино хугацаанд нядалдаг байх, нядалсан малын нөхөн олговрын санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх санхүүгийн эх үүсвэртэй байх гэх мэт. Дээрх нөхцөл шаардлагуудыг Монгол орны эдийн засаг, мал эмнэлгийн одоогийн хүчин чадал, нөөц бололцоотой харьцуулж үзэхэд шинжлээд нядлах аргыг хэрэглэх боломжгүй байна. Иймд хүн амын дунд тархсан бруцеллёзын халдварталтыг бууруулах зорилгоор мал сүргийг массаар вакцинжуулж бруцеллёзын халдвартархах гинжин хэлхээг таслан, улмаар эрүүлжүүлэх нөхцөл бүрдүүлэх замаар тэмцэх нь манай орны хувьд хамгийн үр дүнтэй юм.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2015 оны байдлаар бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх арга хэмжээний хүрээнд жил болгон төл малыг вакцинжуулалт хийдэг. 2015 онд 32,3 мянган тугал, 450,4 мянган хурга, 297,8 мянган ишиг, нийт 780,6 мянган мал бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамрагдсан.

Сүхбаатар аймгийн хэмжээний бүх хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний халдварталтын түвшин тогтоох түүвэр шинжилгээг 12,4 мянган малд хийхэд шинжилгээгээр бруцеллёз өвчний хээлтүүлэгчийн халдварталт 0,7 хувь байгаа нь улсын дундажаас 0,1 хувиар их байна.

## ХОЁР: СТРАТЕГИ ЗОРИЛГО

Нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт ноцтой хохирол учруулдаг малын бруцеллёзын халдварталт, тархалтыг хянах зорилгоор өргөн дархлаажуулалт хийж, улмаар мал сүргийг эрүүлжүүлэх ажлын үндэс суурийг тавихад оршино.

## ГУРАВ: СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

**Зорилт 1:** Малын бруцеллёстой тэмцэх ажлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

### А. Хэрэгжүүлэх арга зам:

1. Малын бруцеллёзоос сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх үед мөрдөх “Стандарт ажиллагааны заавар” /САЗ/-ыг шинчлэн боловсруулахад санал оруулах.

2. Малын бруцеллёзын оношлогоо, лабораторийн шинжилгээний фармокапейн өгүүлэл /ФӨ/, стандарт арга, зааврыг шинэчлэх болон шинээр боловсруулах.

3. Бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалт хийх, тандалт шинжилгээний дээж авах үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоох.

4. Бруцеллёзоос сэргийлэх РЕВ 1, Штамм 19 вакциныг зааврыг шинээр болон шинэчлэн боловсруулах.

5. Уг өвчнөөр эрүүлжсэн суурийг батламжлах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

6. Салбар дундын болон салбар хоорондын хүн, малын өвчлөлийн талаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах тогтолцоог бүх шатанд нэвтрүүлэх, журам боловсруулж мөрдөх.

### Б. Хүлээгдэж буй үр дүн

1. Бруцеллёстой тэмцэхэд шаардагдах ФӨ, стандарт, заавар, журам, шинжилгээний аргууд шинээр болон шинэчлэгдэн боловсрогдоно.

2. Бруцеллёзын тархалтыг хяналтад авч, улмаар эрүүлжүүлэх нөхцөл бүрдэнэ.
3. Уг өвчинөөс сэргийлэх тэмцэх арга хэмжээний төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчин боловсронгуй болно.
4. Салбар хоорондын “Нэг эрүүл мэнд” зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжиж ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирна.

**Зорилт 2: Малын бруцеллёзын халдварлалт тархалтыг хяналтад авах, эрүүлжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.**

**А. Хэрэгжүүлэх зам:**

1. Жил бүр хурга, ишиг, эм тугалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дархлаажуулах.
2. Бруцеллёзын тохиолдлыг тогтоох зорилтот шинжилгээ хийх, эрсдлийн түвшнийг тогтоох.
3. Бруцеллёзын голомтод САЗ-ыг баримтлан ажиллах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.
4. Эрчимжсэн аж ахуйн мал сүргийг эрүүлжүүлэх шинжилгээнд жил бүр бүрэн хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.
5. Эрүүлжүүлэх болон тандалт шинжилгээнд хамрагдсан малыг ээмэгжүүлэх, бог малыг суурийн кодоор бүртгэлжүүлэх.
6. Бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан тухай анхан шатны бичиг баримтын бүрдлийг сайжруулах.
7. Бруцеллёзын дархлаажуулалтанд шаардагдах вакцин, үйлчилгээний хөлс, вакцины дараах тандалтын зардлыг жил тутам улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.
8. Өвчтэй малыг нядлуулсны нөхөн төлбөрийг орон нутгийн төсөвт тусгаа ажлын хэрэгжилтийг хангуулах.

**Б. Хүлээгдэж буй үр дүн**

1. Малын бруцеллёзын тархалт, халдварлалтын эрсдлийг бууруулна.
2. Жил бүрийн дархлаажуулалтад хамрагдсан малын 65-аас доошгүй хувьд дархлаа тогтсон байна.
3. Мал эмнэлгийн арга хэмжээний анхан шатны бүртгэл, бичиг баримт бүрдүүлэлт сайжирна.

**Зорилт 3: Малын бруцеллёзын тандалт шинжилгээ, дархлаажуулалтын үр дүнг үнэлэх /мониторинг/**

**А. Хэрэгжүүлэх арга зам:**

1. Тэмээ болон бух, хуц, ухныг бруцеллёзын шинжилгээнд жил бүр 2-оос доошгүй удаа хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.
2. Бруцеллёзын голомтыг үндэслэн эрсдэл бүхий малчид, мал аж ахуйн мэргэжилтэн, хот суурин газрын хүн амыг хүн эмнэлгийн байгууллагатай хамтран тандалт судалгаа, шинжилгээнд хамруулах.
3. Мал нядалгааны газрууд, махны үйлдвэрүүдэд бруцеллёзын тандалт хийдэг үйл ажиллагааг тогтмолжуулах.
4. Малын бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалтын дараах үнэлгээ /мониторинг/-ний тандах судалгааг жил бүр 6-аас доошгүй суманд зохион байгуулах, үр дүнг тооцох.

5. Эрсдэлтэй бүс нутгийн мал аж ахуйн мэргэжилтэн, малчид иргэдээс бруцеллёзын талаар тандах асуумж судалгааг жил бүр хийх.

6. Гахайн аж ахуйг улирал бүр шинжилгээнд бүрэн хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.

7. Малын бруцеллёзыг хяналтанд авах арга хэмжээний хэрэгжилтэнд явцын болон эцсийн шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

**Б. Хүлээгдэж буй үр дүн:**

1. Малын бруцеллёзын тархалт, халдварталтын түвшин, эрсдэлд шинжлэх ухааны үндэстэй үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний бодлого, чиглэлийг тодорхойлох боломж бүрдэнэ.

**Зорилт 4: Бруцеллёзын оношлогооны чадавхи, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулах.**

**A. Хэрэгжүүлэх арга зам:**

1. Аймгийн мал эмнэлгийн лабораторийн бруцеллёзыг оношлох шинжилгээний чадавхийг сайжруулах, сургалтанд суулгах, дотоодын үр чадварын үнэлгээнд хамруулах, шаардагдах тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, оношуур, эм урвалжаар хангах.

2. Аймгийн хэмжээнд мал сүргийн дунд тархсан “бруцеллёз”-ын төрөл, зүйл, био хэвшлийг тогтоох, тогтоолгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3. Тэмээ болон хуц, ухна /дархлаажуулах/-ны бруцеллёзтой тэмцэх ажлыг шинжлэх ухааны нотолгоонд үндэслэн тодорхой болгох, хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.

4. Мал эмнэлгийн чиглэлийн мэргэжилтэн, боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах.

5. Бруцеллёзтой тэмцэх чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

6. Нохойг бруцеллёзын тандалт шинжилгээ, судалгаанд хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.

**Б. Хүлээгдэж буй үр дүн:**

1. Бруцеллёзын оношлогоо, шинжилгээний чадавхи бүх түвшинд сайжирна.

2. Боловсон хүчний хангамж, чадвар бүх шатанд сайжирна.

3. Тэмээ болон хээлтүүлэгч мал, нохойн бруцеллёзтой тэмцэх ажлын эхлэл шинжлэх ухааны нотолгоонд үндэслэн гарна.

**Зорилт 5: Ухуулга сурталчилгаа, нийгмийн боловсролыг дээшлүүлэх**

**A.Хэрэгжүүлэх арга зам:**

1. Бруцеллёзын хор хөнөөлийн талаархи мэдээллийг тодорхой төлөвлөлт, график, цаг хугацааны дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явуулах /шторк, ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг гэх мэт/.

2. Дархлаажуулалт хийхийн өмнө аймаг, сумдын холбогдох мэргэжилтэн, малын эмч нарт дархлаажуулалтын ач холбогдол, зохион байгуулалтын арга хэлбэр, холбогдох заавар, зөвлөмжийн талаар сургалт,, сурталчилгааг зохион байгуулах.

3. Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа удирдах ажилтан, мэргэжилтэн, малчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

4. Мал төллөх, саалийн үе, мал нядлах, түүхий эд бэлтгэх, боловсруулах, худалдаалах болон аялал-амралтын хугацаанд тодорхой орон нутаг, шазарт бруцеллёзын хор хөнөөлийн талаар ухуулга, сурталчилгаа хийх.

#### Б. Хүлээгдэж буй үр дүн

1. Бруцеллёзын талаарх нийтийн эрүүл мэндийн мэдлэг, боловсрол дээшилнэ.
2. Бруцеллёзын хор хөнөөлийн талаар ухуулга, сурталчилгааны ажил тогтмолжиж хүн уг өвчний халдварт авах эрсдэл мэдэгдэхүйц буурна.

Малын бруцеллёзоос сэргийлэх өргөн дархлаажуулалтын  
арга хэмжээний гарфик төлөвлөгөө

Аймаг	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
CY				M	T	T	T	T	T	T	T	T

Тайлбар: М – хээлтүүлэгчээс бусад бүх мал /үхэр, хонь, ямаа/-ын дархлаажуулалт  
Т - зөвхөн шинэ төл /бүх хурга ишиг, зөвхөн эм тугал/-ийн дархлаажуулалт

### **ДӨРӨВ: СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

#### **5.1. Зохион байгуулалт**

Стратеги хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудынхаа үйл ажиллагааг Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, мал эмнэлгийн хэлтэс нь уялдуулан зохицуулах бөгөөд сум, орон нутгийн холбогдох байгууллага хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, тайлагнана.

Уг стратегийн хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь улсын төсөв, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн дэмжлэг, хандив тусlamж, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

#### **5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

Төрийн болон төрийн бус байгууллага хамтран тус стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрсэн түвшинг тогтооно.

Үнэлгээний дүнг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Аймгийн ИТХ-д танилцуулах, олон нийтэд мэдээлэх, хамтран ажилладаг байгууллагуудтай мэдээлэл солилцох, гарсан дүгнэлтийг дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ашиглах арга хэмжээг зохион байгуулахын зэрэгцээ бүс нутаг, дэлхийн хэмжээний хурал, уулзалт, завлагаанд оролцож мэдээлэл, туршлага солилцено.

Шаардлагатай тохиолдолд олон улс болон дотоодын холбогдох байгууллага, мэргэжлийн шинжээчдээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ.

Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2016 оны 04..дугаар сарын 25..өдрийн  
25....тогтоолын 2-р хавсралт

**БРУЦЕЛЛЁЗТОЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР 2016-2021 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамtran ажиллаж байгууллага
-----	---------------------------	---------	----------------------	-----------------------------

Зорилт 1: Малын бруцеллёзтой тэмцэх ажлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох

1.1.	Өвчтэй малыг нядлуулсан нөхөн төлбөрийг орон нутгийн төсөвт суулгах, олгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2021 он	АЗДТГ ХХААГ	ХХААЯ, МЭҮГ
1.2	Салбар хоорондын хүн, малын өвчлөлийн талаар мэдээлэл солилцох, хамtran ажиллах.	2016-2021 он	ХХААГ	ЭМГ, ЗДТГ
1.3	Бруцеллёз өвчнөөр эрүүлжсэн эрчимжсэн аж ахуй малыг эрүүлжсэнийг батламжлах, эрх зүйн орчинг буй болгох	2016-2021 он	ХХААГ	ХХААЯ, МЭҮГ

Зорилт 2: Малын бруцеллёзын халдварталт тархалтыг хяналтанд авах, эрүүлжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

2.1.	Жил бүр бүр хурга, ишиг, эм тугалыг вакцинжуулах	2016-2021 он	ХХААГ	СЗДТГ, МЭҮТ МЭҮҮН
2.2.	Дараа жилийн вакцинжуулалтад хамрагдах малын тоог малын өсөлтийн сүүлийн 5 жилийн дундажийг харгалзан тогтоох	2016-2021 он	ХХААГ	СЗДТГ, МЭҮТ
2.3.	Хүн, малын халдварын шинэ тохиолдол бүртгэгдсэн үед зорилтот шинжилгээ хийх, эрсдлийн түвшинг тогтоох	2016-2021 он	ХХААГ, МЭХ	АМЭАЦЛ, МЭҮТ, МЭҮҮН
2.4.	Үг өвчинтэй тэмцэх зааврын дагуу хязгаарлалтын болон тэмцэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2021 он	МЭҮГ, АМЭХ, МЭҮҮН	ЗӨСҮТ, хүн эмнэлгийн байгууллага
2.5.	Эрчимжсэн аж ахуйн мал сүргийг жил бүрийн төлөвлөгөөт эрүүлжүүлэх шинжилгээнд хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2021 он	ХХААГ, МЭХ-Н МЭАЦЛ	МЭҮТ, МЭҮҮН
2.6.	Бод малыг ээмэгжүүлэх, бод малыг суурийн кодоор бүртгэлжүүлэх	2016-2021 он	ХХААГ	МЭҮТ, МЭҮҮН

Зорилт 3: Малын бруцеллёзын тандалт шинжилгээ, вакцинуулалтын үр дүнг үнэлэх /мониторинг/

	ажлыг эрчимжүүлэх			
2.7.	Вакцинуулалт хийсэн бичиг баримтын анхан шатны бүрдлийг ханган ажиллах	2016-2021 он	МЭХ	МЭҮТ, МЭҮҮН
2.8.	Вакцин хадгалах, зөөвөрлөх зориулалтын байр, тээврийн хэрэгсэл, багаж хэрэгслээх хангах асуудлыг бүх шатанд шийдвэрлэх, зориулалтын байр, хөргүүр болон хяналтын термометрийн ашиглалтыг сайжруулах	2016-2021 он	ХХАЯЯ, МЭҮГ	МЭХ, МЭҮТ, МЭҮҮН
2.9.	Бруцеллёзын тохиолдол бүрийг бүртгэл, мэдээлэлд бүрэн хамруулах, мэдээллийн сан бүрдүүлэх.	2016-2021 он		

Зорилт 3: Малын бруцеллёзын тандалт шинжилгээ, вакцинуулалтын үр дүнг үнэлэх /мониторинг/

3.1.	Тэмээ болон бух, хуц, ухныг бруцеллёзын шинжилгээнд жил бүр 2-оос доошгүй удаа хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.	2016-2021 он	МЭХ	ИЭҮТ, МЭҮҮН
3.2.	Бруцеллёзын голомтыг үндэслэн эрсдэл бүхий иргэд /малчид мал аж ахуйн мэргэжилтэн/ хот суурин газрын хүн амьг хүн эмнэлгийн байгууллагатай хамтран тандалт, шинжилгээ, судалгаанд хамруулах	2016-2021 он	ХХААГ, МЭҮГ	ХӨСҮТ, АМЭХ, МЭҮТ, сумын хүн эмнэлэг
3.3.	Мал нядалгааны газрууд, махны үйлдвэрүүдэд бруцеддёзын тандалт хийдэг тотолцоог бий болгох.	2016-2021 он	ХХААГ АМЭАЦЛ	МЭҮТ, МЭҮҮН
3.4.	Вакцины дараах урвалын дүнг хянах тандах судалгааг жил бүр 3-4 суманд зохион байгуулах, үр дүнг тооцох.	2016-2021 он	АМЭХ	МЭМТ, МЭҮҮН
3.5.	Эрсдэлтэй бүс нутгийн мал аж ахуйн мэргэжилтэн, малчид иргэдээс тандах асуумж судалгааг авах	2016-2021 он	ХХААГ, МЭҮТ	СЗДТГ, МЭҮТ
3.6.	Гахайн аж ахуйн улирал бүр шинжилгээнд хамруулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2021 он	МЭҮГ АМЭХ	МЭҮТ, МЭҮҮН

Зорилт 4: Бруцеллёзын оношлогооны чадавхи, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулах

4.1.	Аймгийн лабораторийн чадавхийг дээшлүүлэх, үр чадварын	2016-2021 он	ХХААГ, АМЭАЦЛ	МЭХ, МЭҮГ. УМЭАЦТЛ
------	--	--------------	------------------	-----------------------

	үнэлгээнд хамрагдах			
4.2.	Бүх түвшиний лабораторийн бруцеллээс оношлох шинжилгээний чадавхийг сайжруулах, сургалт, ур чадаварын үнэлгээнд хамруулах, шаардагдах тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, оношлуур, эм урвалжаар хангах.	2016-2021 он	ХХААЯ, МЭҮГ	МЭХ, АМЭАЦЛ
4.3.	Боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтанд малын эмч, лабораторийн эмч нарыг тусгай хөтөлбөрийн дагуу ялгавартайгаар хандах, хамруулах	2016-2021 он	МЭҮГ, УМЭАЦТЛ, АМЭАЦЛ	МЭМТ, болон төсөл хөтөлбөр
4.4.	Бруцеллээс өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах	2016-2021 он	ХХААЯ, МЭҮГ, ХХААГ	Төслийн байгууллага
4.5.	Нохойг бруцеллёзын тандалт шинжилгээ, судалгаанд хамруулах	2016-2021 он	АМЭАЦЛ	МЭХ

**Зорилт 5: Ухуулга сурталчилгаа, нийгмийн боловсролыг дээшлүүлэх**

5.1.	Хүн, малын бруцеллээс өвчний талаарх мэдээллийг, тодорхой түвшинд солилцох, төлөвлөлт, график, цаг хугацааны дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх. /шторк, ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг г. м /	2016-2021 он	ХХААГ, МЭХ, МЭАЦЛ	Олон улсын төсөл хөтөлбөр, MoYМЭХ
5.2.	Жил бүр өргөн вакцинуулалт хийхийн өмнө аймагт сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах	2016-2021 он	ХХААГ, МЭҮГ	МЭМТ, МЭЭСБУЛ Биокомбинат MoYМЭХ
5.3.	Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа удирдах ажилтан, мэргэжилтэн, малчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.	2016-2021 он	МЭҮГ, ХХААГ МЭХ	МЭХ, УМЭАЦТЛ МЭБС, МЭМТ, MoYМЭХ
5.4.	Мал төллөх, саах үеэр болон мал нядлах, түүхий эд бэлтгэх, боловсруулах, худалдаалах болон аялал-амралтын газарт ухуулга зөвлөмж өгөх, хуудас наах зэргээр мэдээлэл тараах	2016-2021 он	ХХААГ МЭХ, МЭАЦЛ	СЗДТГ, МЭҮТ, МЭҮҮН
5.5.	Төрийн ба төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, хамт олон, иргэдийн идэвхи санаачлагыг дэмжиж ажиллах	2016-2021 он	ХХААГ, МЭХ	МЭЭШХ, УМЭАЦТЛ MoYМЭХ МЭМТ